

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/88/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БГ	Боловсролын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН 23 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

Ард. Д. Д. Д. № 89

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. □

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг □онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 17,239.5 мянган төгрөгийн компьютер, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч, эцэг эхийн хандиваар 1,600.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 661,182.9 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 41.0 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 44 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98.6 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	130,388,284.00	209,700,564.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	110,321,389.00	179,570,879.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах	110,321,389.00	179,570,879.00
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	20,066,895.00	30,129,685.00
351	Түүхий эд материал	546,000.00	577,400.00
3511	Тусгай зориулалттай материал	-	-
3513	Эм боох материал	546,000.00	577,400.00
354	Хангамжийн материал	19,520,895.00	29,552,285.00
35410	Бичиг хэргийн материал	576,800.00	2,738,000.00
35420	Аж ахуйн материал	14,650,613.00	21,050,903.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	-	-
3545	Барилгын засварын материал	2,375,000.00	2,375,000.00
3546	Хүнсний материал	1,918,482.00	3,388,382.00
35470	Бусад хангамжийн материал	-	-
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,276,845,184.92	1,277,197,056.14
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,276,845,184.92	1,277,197,056.14
392	Биет хөрөнгө	1,084,695,184.72	1,085,047,056.14
39201	Барилга, байгууламж орон сууц	1,120,749,769.00	1,120,749,769.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(86,928,887.16)	(106,120,128.24)
39203	Авто тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,160,219.00	73,168,819.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,945,541.82)	(33,370,557.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,404,976.00	30,630,050.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,005,054.24)	(13,304,841.71)
39214	Бусад үндсэн хөрөнгө	70,605,361.50	21,792,130.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(58,642,018.60)	(11,794,546.08)
39217	Ном	3,296,361.04	3,296,361.04
393	Биет бус хөрөнгө	192,150,000.20	192,150,000.00
39301	Программ хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,299.80)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	192,150,000.00	192,150,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,407,233,468.92	1,486,897,620.14

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,407,233,468.92	1,486,897,620.14
51	Засгийн газрын хувь оролцоо	1,407,233,468.92	1,486,897,620.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	597,694,037.00	597,694,037.00
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	(46,797,337.21)	32,866,814.01
51210	Өмнөх үеийн үр дүн	(46,797,337.21)	(46,797,337.21)
51220	Тайлант үеийн үр дүн	-	79,664,151.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	856,336,769.13	856,336,769.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,407,233,468.92	1,486,897,620.14




2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	787,536,400.00	1,034,596,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,436,000.00	33,388,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,436,000.00	33,388,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	3,386,000.00	27,179,500.00
120045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	2,050,000.00	6,208,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	782,100,400.00	1,001,208,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	737,800,400.00	945,167,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,300,000.00	56,041,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	44,300,000.00	56,041,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	724,916,742.45	954,932,748.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	724,916,742.45	954,932,748.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	724,885,513.85	950,614,516.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468,899,672.00	661,182,994.00
210101	Үндсэн цалин	318,210,306.00	467,144,995.00
210102	Нэмэгдэл	132,576,004.00	169,504,369.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамцуулал	18,113,362.00	24,533,630.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,238,923.00	86,301,696.00
210201	Тэтгэврийн даатгал	45,921,699.00	58,910,981.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,324,116.00	7,338,921.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,231,373.00	3,370,011.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,084,330.00	3,336,354.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,677,405.00	13,345,429.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,568,771.40	42,723,567.25
210301	Гэрэл, цахилгаан	6,770,961.45	6,577,303.49
210302	Түлш, халаалт	20,670,188.89	22,955,202.60
210303	Цэвэр, бохир ус	11,127,621.06	13,191,061.16
210304	байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	12,647,073.00	3,831,880.00
210401	Бичиг хэрэг	3,151,250.00	1,616,200.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00




210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	9,495,823.00	2,215,680.00
2105	Нормативт зардал	88,527,682.00	95,213,420.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	437,450.00	0.00
210502	Хоол, хүнс	88,090,232.00	95,213,420.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	8,040,948.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	0.00	8,040,948.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,082,200.00	1,381,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,082,200.00	1,381,200.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,921,192.45	51,938,810.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,518,040.00	11,284,972.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	7,617,710.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,403,152.45	33,036,128.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,228.60	4,318,232.75
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,228.60	4,318,232.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,228.60	4,318,232.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	62,619,657.55	79,664,151.22
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	62,619,657.55	79,664,151.22



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	782,100,400.00	1,001,208,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	782,100,400.00	1,001,208,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	737,800,400.00	945,167,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	737,800,400.00	945,167,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,300,000.00	56,041,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,300,000.00	56,041,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	684,670,625.00	931,959,410.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,670,625.00	931,959,410.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684,639,396.40	927,641,177.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	468,899,672.00	661,182,994.00
210101	Үндсэн цалин	318,210,306.00	467,144,995.00
210102	Нэмэгдэл	132,576,004.00	169,504,369.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	18,113,362.00	24,533,630.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,238,923.00	86,301,696.00
210201	Тэтгэврийн даатгалын	45,921,699.00	58,910,981.00
210202	Тэтгэмжийн даатгалын	5,324,116.00	7,338,921.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	4,231,373.00	3,370,011.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,084,330.00	3,336,354.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	10,677,405.00	13,345,429.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,568,771.40	42,723,567.25
210301	Гэрэл, цахилгаан	6,770,961.45	6,577,303.49
210302	Түлш, халаалт	20,670,188.89	22,955,202.60
210303	Цэвэр, бохир ус	11,127,621.06	13,191,061.16
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материал	-	-
210401	Бичиг хэргийн зардал		
210402	Тээвэр шатахуун		
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
210408	Бараа материал акталсны зардал		



2105	Нормативт зардал	87,856,760.00	96,683,320.00
210502	Хоол, хүнс	87,856,760.00	96,683,320.00
2106	Эд хогшил урсгал засвар	1,300,000.00	9,000,000.00
210601	Багаж техник хэрэгсэл		
210602	Тавилга		
210604	Урсгал засвар	1,300,000.00	9,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	1,366,500.00	1,549,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил , үйлчилгээний төлбөр, хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	тээврийн хэрэгслийн татвар	-	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,366,500.00	1,549,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,408,770.00	30,200,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,130,170.00	20,260,500.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,278,600.00	9,939,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,228.60	4,318,232.75
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,228.60	4,318,232.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,228.60	4,318,232.75
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	97,429,775.00	69,249,490.00
	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	4,400,000.00	-
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(4,400,000.00)	-
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	93,029,775.00	69,249,490.00
9	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,291,614.00	110,321,389.00
10	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	110,321,389.00	179,570,879.00

ХТ05430@9022899

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	597,694,037.00	856,336,769.13	(46,797,337.21)	-	1,407,233,468.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	597,694,037.00	856,336,769.13	(46,797,337.21)	-	1,407,233,468.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			-		-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	597,694,037.00	856,336,769.13	(46,797,337.21)	-	1,407,233,468.92
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	597,694,037.00	856,336,769.13	(46,797,337.21)	-	1,407,233,468.92
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			79,664,151.22		79,664,151.22
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	597,694,037.00	856,336,769.13	32,866,814.01	-	1,486,897,620.14



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,111,530,200.00	927,641,177.25	(183,889,022.75)	83.5%
21	Урсгал зардлын дүн	1,111,530,200.00	927,641,177.25	(183,889,022.75)	83.5%
210	Бараа үйлчилгээний зардал	1,111,530,200.00	927,641,177.25	(183,889,022.75)	83.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	813,453,500.00	661,182,994.00	(152,270,506.00)	81.3%
210101	Үндсэн цалин	590,384,400.00	467,144,995.00	(123,239,405.00)	79.1%
210102	Нэмэгдэл	210,066,500.00	169,504,369.00	(40,562,131.00)	80.7%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	-	-
210104	Урамшуулал	13,002,600.00	24,533,630.00	11,531,030.00	188.7%
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,878,700.00	86,301,696.00	(7,577,004.00)	91.9%
210201	Тэтгэврийн даатгал	63,839,500.00	58,910,981.00	-	92.3%
210202	Тэтгэмжийн даатгал	7,508,400.00	7,338,921.00	-	97.7%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,755,000.00	3,370,011.00	-	89.7%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,755,000.00	3,336,354.00	-	88.9%
210205	ЭМД-ын хураамж	15,020,800.00	13,345,429.00	-	88.8%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,041,800.00	42,723,567.25	(4,318,232.75)	90.8%
210301	Гэрэл цахилгааны зардал	7,885,300.00	6,577,303.49	-	83.4%
210302	Түлш, халаалтын зардал	23,647,200.00	22,955,202.60	-	97.1%
210303	Цэвэр бохир усны зардал	15,509,300.00	13,191,061.16	-	85.1%
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	-	-
2105	Нормативт зардал	108,862,600.00	96,683,320.00	(12,179,280.00)	88.8%
210501	Эм	-	-	-	-
210502	Хоол хүнс	108,862,600.00	96,683,320.00	(12,179,280.00)	88.8%
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00	9,000,000.00	-	100.0%
210601	Багаж хэрэгсэл	-	-	-	-
210602	Тавилга	-	-	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	-	-	-
210604	Урсгал засвар	9,000,000.00	9,000,000.00	-	100.0%
2107	Томиллолт, зочны зардал	-	-	-	-
210702	Дотоод томиллолт	-	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	3,181,500.00	1,549,200.00	(1,632,300.00)	48.7%
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,181,500.00	1,549,200.00	(1,632,300.00)	48.7%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,112,100.00	30,200,400.00	(5,911,700.00)	83.6%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,172,200.00	20,260,500.00	(5,911,700.00)	77.4%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,939,900.00	9,939,900.00	-	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	-

ХТ05430-9022899

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	-
213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг			-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	-	-
213204	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал			-	-
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал			-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			-	-
	Дотоод эх үүсвэрээр			-	-
	Тоног төхөөрөмж			-	-
	Бусад хөрөнгө			-	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,111,530,200.00	996,890,667.25	(114,639,532.75)	89.7%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,055,488,400.00	945,167,100.00	(110,321,300.00)	89.5%
131001	Улсын төсвөөс санхүүжих	945,167,100.00	945,167,100.00	-	100.0%
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	110,321,300.00		(110,321,300.00)	0.0%
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-		0.0%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			-	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,041,800.00	51,723,567.25	(4,318,232.75)	92.3%
132001	Орон нутгийн төсвөөс	56,041,800.00	51,723,567.25	(4,318,232.75)	92.3%
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		110,321,389.00	110,321,389.00	
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		179,570,879.00	179,570,879.00	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100%
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100%
	АЖИЛЛАГСДЫН ТОО	34.00	34.00	-	100%
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100%
	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	-	100%
	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	-	100%



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Сургуулийн өмнөх салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилт”-ийг хэрэгжүүлж, сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулна гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах 8 зорилт дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Математикт суурилсан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах
- Хүүхдийг хэл ярианы хөгжлийг дэмжих зургаар унших чадварыг хөгжүүлэх
- “Харилцан суралцаж хамтдаа хөгжицгөөе” уриан дор МБНБ-ээр ажиллах
- Монгол хүүхэд төлөвшил, зан чанарын сургалтыг хүүхэд эцэг эх, багш ажилчдын дунд явуулах, улирал бүр багш ажилчдын дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх бүтээлч ажлыг зохион байгуулах
- Гүйцэтгэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж амжилтыг ахиулах
- Улс, аймаг, орон нутгийг сургалтуудад багш ажилтныг бүрэн хамруулж чадавхжуулах
- Ялгаатай, хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулж, эцэг эх асран хамгаалагчтай хамтран хөгжлийг дэмжих
- Хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн шим тэжээллэг хоол хүнсээр хангаж ажиллах

Байгууллагын гадаад, дотоод орчин

Дархан-Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолоор
- “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор
- “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоолоор
- “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох” журам Монгол улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоолоор
- “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 237 тоот тогтоолоор

- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 тоот “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай” тушаал

- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 115 тоот “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх” тушаал

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,671.2 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	110,321.4	179,570.9	69,249.5
Бараа материал	20,066.9	30,129.7	10,062.8
Үндсэн хөрөнгө	1,276,845.2	1,277,197.0	351.8
Нийт хөрөнгө	1,407,233.5	1,486,904.6	79,671.2
Өр төлбөр	-	-	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,407,233.5	1,486,904.6	79,671.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,407,233.5	1,486,904.6	79,671.2

Тайлант онц эцэст төвлөрсөн мөнгөнөөс 69,249.5 мянган төгрөг үлдэж, төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэл 179,570.9 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30,129.7 мянган төгрөг болж 10,062.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 121,810.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 111,747.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,277,197.0 мянган төгрөг болж 351.8 мянган төгрөгөөр өссөн нь эцэг эхийн хандиваар 1,600.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 9 ширхэг 17,239.5 мянган төгрөгийн компьютер, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 1 ширхэг 8,200.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч буюу нийт 27,039.5 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 01А/313 тоот захирамжаар 17 нэр төрлийн 83,747.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, ашиглалтын хугацаа дууссан дахин ашиглах боломжтой 10 нэр төрлийн 7,219.9 мянган төгрөгийн хөрөнгүүдийг ОНӨГ-ын даргын 2024 оны А/16 тоот тушаалын дагуу дахин үнэлж, тайлант онд 33,029.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,486,904.6 мянган төгрөг болж 79,671.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 860,845.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 56,041.8 мянган төгрөг буюу нийт 916,887.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2024 оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 945,167.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 56,041.8 мянган төгрөг буюу нийт 1,001,208.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 945,167.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 56,041.8 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 110,321.3 мянган төгрөг буюу нийт 1,111,530.2 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 56,041.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 51,723.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 4,318.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, улсын төсвөөс 945,167.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 875,917.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 69,249.5 мянган төгрөг харилцах дансанд үлдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 927,641.2 мянган төгрөг буюу 83.5 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 183,889.1 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	3,571.1	1,616.0	(1,955.1)	45.3%
2	80233	Хүүхэд хамгаалал	1,456.0	1,456.0	-	100.0%
3	80111	Тогтмол зардал	56,041.8	56,041.8	-	100.0%
4	81807	Хүүхдийн хоол	108,863.0	96,683.3	(12,179.7)	88.8%
5	81823	Багш ажилдчын мэргэжил дээшлүүлэх	2,623.1	1,585.0	(1,038.1)	60.4%
6	81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	4,133.3	4,133.5	0.2	100.0%
7	81834	Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	922,717.0	754,000.6	(168,716.4)	81.7%
8	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	12,125.0	12,125.0	-	100.0%
		Дүн	1,111,530.3	927,641.2	(183,889.1)	83.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 22 ажилтан, үйлчлэх 11 ажилтан буюу нийт 34 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 20,260.5 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээ шууд байгуулахаар 22,938.2 мянган төгрөг, нээлттэй аргаар 93,657.0 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааг сар тутам зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын бараа ажил, үйлчилгээний төлбөр тооцоо, зардлын данс болон Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 724,916.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,249.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 187.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	1	187.5	1	187.5	100%
Нийт дүн	1	187.5	1	187.5	

/мянган төгрөг/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан 862,725.4 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 82,441.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 204,675.0 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 93.1 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,316.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох 2,316.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Тайлант онд байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан шалтгаанаар Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан цэцэрлэгийн эрхлэгч үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж, 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн эрхлэгч Д.Эрдэнэчимэгийг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 1.5 дахин нэмэгдүүлэн 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал олгосонд албан шаардлага хүргүүлээ.	1	2,316.0			1	2,316.0						
Дүн	1	2,316.0	-	-	1	2,316.0	-	-	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Үүнээс

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус цэцэрлэг нь Ахмад настны тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-